

КРИМИНАЛИСТИКИЙН БҮРТГЭЛ ҮҮСЭЖ ХӨГЖСӨН ЯВЦ

Баасанням Буянхишиг
Шүүхийн шинжилгээний үндэсний
хүрээлэнгийн тамгын хэлтсийн мэргэжилтэн

Хүн төрөлхтний түүхэнд аливаа гэмт явдалтай тэмцэхэд бүртгэлийн арга зүйг эрт дээр үеэсхэрэглэж, ашиглаж ирснийг түүхийн эх сурвалжууд баталдаг. Криминалистикийн /эрүүгийн/ бүртгэл анх хэзээ, хаана үүссэн бэ? гэсэн эхлэлийн цэгийг нарийн тогтоосон асуултанд орчин үеийн криминалистикийн шинжлэх ухаан ямар нэг маргаангүй, нэг утгатай хариултыг өгч чадаагүй байна.

Доктор (Ph.D), профессор Б.Бат-Эрдэнэ “Криминалистикийн бүртгэл-Эрэл, адилтгал хийхийн тулд гэмт хэрэг, гэмт хэрэгтэн болон бусад объектын тухай мэдээлэл цуглуулах, бүртгэх, баяжуулах болон боловсруулах зорилгоор хөтөлдөг шинжлэх ухааны үндэстэй мэдээллийн тусгай тогтолцоо” гэж криминалистикийн бүртгэлийг тодорхойлсон.¹

Гэвч гэмт хэрэгтнийг бүртгэх бүртгэлийн анхны аргууд нь тамгалах, зэрэмдэглэх, шивээс хийх аргууд байсан бөгөөд тэдгээр нь тодорхой утга санааг илэрхийлсэн үсэг, дүрсүүд бүхий нэн хэрцгий, хүнлэг бус аргууд байв. Эртний Грек, дундад зууны үеийн Англи, Франц, Герман болон бусад орнуудад гэмт хэрэгтнийг зэрэмдэглэх арга нь 2 төрлийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь нэг талаас гэмт этгээдэд хэрэг үйлдсэний төлөө үзүүлж буй ял шийтгэл, нөгөө талаас дээрх этгээд урьд өмнө гэмт хэрэг үйлдэж байсан болохыг нотлох үүргийг гүйцэтгэж байв.

Орос улсад биеийн эд, эрхтэнг зэрэмдэглэх эдгээр аргуудыг 1497 онд Иван III хаан албан ёсоор хуульчлах хүртэл тодорхой эрх мэдэлтний зааврыг мөрдөж байсан бөгөөд хууль зүйн нарийн зохицуулалт байсангүй. Хүний эд, эрхтэнг гэмтээх шийтгэлийг 1817 онд халжээ.²

Петр I-ийн хаанчлалын үед “В”, дараа бүргэдийн дүрс болгосон-хулгайч, “У”-алуурчин, “Л”-худалч, “КАТ”, “СК”, “СП” гэх мэт тодорхой үсэг, томъёолсон дүрс бүхий тамгалах, шивээс хийх аргыг хослуулсан тамгыг гэмт хэрэгтний дух, хацарт зарим тохиолдолд гар, нурууны хэсэгт дарж тэмдэглэдэг байв.³ Мөн гэмт хэрэгтнийг танин олох, эрэн сурвалжлахад ашиглах зорилгоор тэдний гадна дүр төрхийг тодорхойлон бичих аргыг ч тамгалах аргатай хослуулан хэрэглэж байжээ.

XIX зууны үед гэмт хэргийн тоо огцом өсч бүртгэлд хамрагдах хүмүүсийн тоо нэмэгдсэн, өөрөөр хэлбэл маш олон хүмүүсийг тамгалах, зэрэмдэглэх ажил хүлээгдэж байсан, энэ арга нь хэт хоцрогдсон, болхи, хүний биед насан туршид үл арилах шинж тэмдэг, согогийг үлдээдэг гэх мэт олон шалтгааны улмаас дэлхийн ихэнх орнууд энэ бүдүүлэг аргыг хэрэглэхээс татгалзах, бүртгэлийг шинжлэх ухааны үндэстэй шийдвэрлэх асуудалтай тулгарсан байна. ХҮШ зууны сүүлчээр Францад гэмт хэрэг үйлдсэн, ял шийтгэл хүлээсэн хүмүүсийн нэрсийн жагсаалт бүхий тусгай хүснэгт/реестры/⁴бүртгэлийн аргыг хэрэглэж эхэлсэн бөгөөд улмаар 1790 онд “Лавлагааны тусгай товчоо” байгуулагджээ.

1860 оноос Францын нэгэн шоронгийн дарга Стивенс ял эдлэгсдийн анкет, антропометрийн мэдээлэл бүхий бүртгэлийн картыг нэвтрүүлж эхэлсэн нь шинжлэх ухаанд үндэслэгдсэн криминалистикийн бүртгэл бий болж хөгжихөд багагүй үүрэг гүйцэтгэсэн байна.

1874 оноос Парисын цагдаагийн байгууллага гэмт хэрэгтнүүдийг баривчлах, танин олоход ашиглах зорилгоор тэдний гэрэл зургийг цагаан толгойн үсгийн дарааллаар системчилсэн гэрэл зургийн альбомыг хийсэн бөгөөд сэжигтэн этгээд өөрийн овог нэр, бусад өгөгдөхүүнээ нуусан тохиолдолд энэ альбомд түүний зураг байгаа эсэхийг олоход нэр их хөдөлмөр, цаг хугацаа зарцуулагддаг байв.

1879 онд Парисын цагдаагийн ажилтан Альфонс Бертильон дээрх гэрэл зургуудыг тэдний биеийн тодорхой нэг өгөгдөхүүнийг эрэмбэлсэн жагсаалттай уялдуулан байрлуулахыг санал болгосон бөгөөд 1885 онд антропометрийг ашиглахыг Засгийн газарт санал болгосон ч 1888 онд

¹Б.Бат-Эрдэнэ. Криминалистик. Лекц. Улаанбаатар., 2003. 102 дахь тал.

²Булгаков В.Г, Внуков В.И нар “Криминалистическая регистрация”. Волгоград., 2009. 4 дэх тал.

³Мөн тэнд

⁴реестры гэдэг үгнээс регистр гэдэг ойлголт, нэр томъёо бий болсон гэж үздэг.

энэ аргыг ашиглаж эхэлсэн байна.

Альфонс Бертильоныгөнөөгийн цагдаагийн байгууллагуудад хэрэглэж байгаа хүний гадаад шинж тэмдгийг тодорхойлон бичих аман зургийн арга зүй буюу “бертильонаж”-г үндэслэгч гэж үздэг. Антропометрийг үр дүнтэй ашиглаж байсан нэг жишээг дурдвал:

Баривчлагдсан хүмүүсийн чих, хамрын хэлбэр, чац зэргийг харьцуулан судалж байсан нь тухайн үедээ зарим хүмүүст инээдтэй санагдаж байсан боловч багахан хугацааны дараа тэрээр 1800 карт бүхий сантай болж амжсан байв. 1881 оны 02-р сарын 20-нд зургаа дахь “Дюпин”⁵ гэдэг хоригдол иржээ. Бертильон түүний биеийн хэсгүүдийг хэмжиж үзээд картын сангаа шүүгээд: «Та 12-р сарын 15-нд хоосон шил хулгайлсан хэргээр баривчлагдаж байсан Мартин гэгч хүн байна» гэхэд хоригдол «Сайн байна, сайн байна, тэр чинь би байсан юм» гэж хашгирсан байна.⁶

1890 онд Оросын Петербург хотод антропометрийг ашиглаж эхэлсэн бөгөөд улмаар 12 товчоотой /станц гэж бас нэрлэж байсан/ болтлоо өргөжсөн ч өргөн уудам нутаг дэвсгэртэй Орос орны хувьд энэ нь тун хангалтгүй тоо байв.

«Дэлхийн аль ч соёлтойоронд нийтлэг, нэгэн жишгээр хэрэглэх бололцоо бүхий дэвшилттэй аргыг бий болгосонд Бертильоны системийн ач холбогдол оршино»⁷ гэж Ганс Гросс⁸ үнэлсэн байдаг.

Антропометр нь 15-20 жилийн турш гэмт хэрэгтнийг бүртгэх шинжлэх ухаанлаг арга байсан ч удалгүй “Гарын мөр судлал”-ын салбарт бий болсон ололт, дэвшилтэд өөрийн байр сууриа бүрэн алдсан юм.

Гэмт хэрэгтнийг бүртгэхэд гарын хурууны хээг ашиглах санааг Английн шинжээч Ф.Гальтонанх бодож олсон бөгөөд энэ нь “бертильонаж”-аас олон талаар давуутай байсан учир түүнийг шинжлэх ухаанд суурилсан “Криминалистикийн бүртгэл”-ийг үндэслэгч гэж зүй ёсоор хүлээн зөвшөөрдөг.

1891 онд Ф.Гальтон Генритэй хамтран бүртгэлийн аргыг улам боловсронгуй болгов. Эхний үед гэмт этгээдийн гарын хээний бүртгэлд түүний гэрэл зураг, антропометрийн өгөгдөхүүнийг хамт ашигласаар байв.

1906 онд Орос улс гэмт хэрэгтнийг бүртгэхэд “Гарын хээний тоо бүртгэл”-ийг ашиглах тухай шийдвэрийг гаргаснаар 1907 он гэхэд Цагдаагийн газарт Бүртгэлийн төвлөрсөн товчоо /төв/, орон нутагт бүртгэлийн хэлтэс /товчоо/ байгуулагдаж тус улс үндсэндээ зохион байгуулалтын тодорхой бүтэц, үйл ажиллагааны нарийн чиг үүрэг бүхий “Криминалистикийн бүртгэл”-тэй болсон бөгөөд тухайн үед цагдаагийн байгууллага гэмт хэрэгтнийг бүртгэхэд гэрэл зураг, гарын хээний дардас болон антропометрийн зарим хэмжилтийг ашиглаж байлаа. Эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гэмт хэргийн байдлаар нь төрөлжүүлэн эрэмбэлж /литер/ тусгайлан бүлэглэсэн нь ашиглахад ихээхэн хялбар болж зохих үр дүнгээ өгсөн байна.

Монгол улсад эрүүгийн тоо бүртгэл хөтөлж байсан тухай архивын баримтаас үзэхэд Манжийн үед эрүүгийн тоо бүртгэл хөтөлж байсан албан дансыг судалгааны ажлын явцад олж тогтоож чадаагүй ч ийм бүртгэл хөтөлж байсныг заах нугалбар бичгүүд элбэг тохиолддог. Жишээлбэл Тэнгэрийн тэтгэсний 27 дугаар он буюу 1763 онд үйлдсэн нугалбар бичгүүд⁹ дунд эрүүгийн хэргийг бүртгэж байсан тухай зарим мэдээ байна. Үүнд:

Нугалбар 22. Өргөх бичиг. Төгсгөөнд ажиллуулахаар хүмүүсийг хоол хүнс, хоёр хоёр сарын унаа уналгатайгаар Хиагтад ирүүлсэн байх тухай бичиг.

Тэнгэрийн тэтгэсний 27 дугаар он зуны тэргүүн сарын арван дөрвөн.

Нугалбар 31. Хэрлэний барс хотын чуулган дэд тэргүүн, засгийн хошой чин ван Баяршидийн бичиг. Зарлигаар зарсан амбан Хиагтад очиж төгсгөөний хуучин шинэ хэргийг хэлэлцэх тул манай аймгийн хуучин шинэ үгэнд холбогдсон нээгч, нээгдэгч эл ардыг цөмийг энэ зуны тэргүүн сарын арванд Хиагтад хүргэхээр илгээтүгэй хэмээн...

Тэнгэрийн тэтгэсний 27 дугаар он. Зуны тэргүүн сарын 27-ноо.

Жич: Төгсгөөн гэж Орос Монголын хил орчмын эрх бүхүй түшмэд хоёр талаас ирж хоёр талаас хэргийн дансыг гарган харилцан хэлэлцдэг байсныг хэлэх үг тул хэргийг бүртгэсэн данс лав байдаг байсныг гэрчилж байна.

⁵Энэ нэр тэр үеийн гэмт хэрэгтнүүдийн өөрсдийгөө нэрлэх дуртай нэр байжээ.

⁶Хаанаас авсан болохыг дурдах

⁷Ганс Гросс. “Шүүхийн мөрдөн байцаагчийн мөрдлөг нь криминалистикийн тогтолцоо мөн” Москва. 2002., 324 дэх тал

⁸Австрийн эрдэмтэн, криминалистикийн шинжлэх ухааныг үндэслэгч

⁹УАГ. М-1. Т-1. ХН 2876. Нугалбар бичгүүд

Нугалбар 46. Цурхайтын амаар манай Оросоос нэхсэн 139 зүйлийн доторхи баригдсан хулгайч ба мөр тушаасан, жич мөр үгүй нэхсэн, хүн таньсан, зүсээр ор буцааж өгсөн, хий газрын хэрэгтэй бүгд 6 зэрэг ялган салгаж бичсэн товч данс.

Тэнгэрийн тэтгэсний 27 дугаар он...

Энэ нугалбараас үзэхэд бүртгэсэн хэргийг дотор нь хулгайчийг барьж тушаасан, хулгайчийг бариагүй боловч мөрийг мөшгиж тушаасан, мөр тушаагаагүй боловч очиж нэхсэн, хохирлыг барагдуулсан буюу зүсээр ор буцааж өгсөн зэргээр төрөлжүүлдэг байсан байна.

Үүнээс хожуу, бүрэн засагчийн тавдугаар онд¹⁰ үйлдсэн нэгэн хадгаламжийн нэгж¹¹ дотор а/ Байгаль орчныг хамгаалах, б/ Гэмт хэрэг, зөрчлийг урьдчилан сэргийлэх, в/ Иргэний бүртгэлийнталаар гэх мэт төрөлжсөн олон нугалбар бичгүүд байдаг.

Монгол оронд эрүүгийн тоо бүртгэл хөтөлж байсан тухай түүхийн зарим сурвалжид дурьдсан байх ба тухайн үед эрүүгийн тоо бүртгэлийг тусгай дэвсгэрт тэмдэглэн бүртгэн бичиж авдаг байсан гэсэн мэдээ байдаг. Тухайлбал: “Улаан хацарт”-д бичсэнээр эрүүгийн тоо бүртгэлд 1820-1913 оны хооронд буюу бараг зуун жилийн туршид ял шийтгүүлсэн 487 гэмт хэрэгтний бүртгэл хадгалагдаж байна¹².

1923 оны Цагаан сараас мөн оны 12-р сарын эцэс хүртэл Шүүх яамны гянданд - 456 хэрэгтэн ялтан хоригдсоноос: Улс төрд тэрсэлсэн - 23, хэрэгт - 145, Хулгайн хийсэн - 192, Мэхлэж улаа хэрэглэсэн - 10, Мөнгө ашигласан - 12, Түр хоригдсон - 16 гэх мэтээр ангилж байжээ.

Монголын цагдаагийн байгууллагын түүхэнд эрүүгийн тоо бүртгэл, шүүх гэрэл зургийг хувьсгалын эхний жилүүдэд ашиглаж байсан түүх бий. 1928 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Улсын дотоодыг хамгаалах газрын 49 тоот тушаалаар шефрийн нууц тусгай тасагт томилогдсон гэрэл зурагчин нь баригдсан дээрэмчид, цагаантны үлдэгдэл, хувьсгалын эсэргүү нарын, мөн гэмт хэрэгтний болон эд мөрийн баримтын зургийг авч хувь хүнийг тогтоох, бүртгэх гол үүргийг гүйцэтгэдэг байжээ.

Түүхэн баримтыг сөхөн үзэхэд энэ үед гэмт хэрэгтний зургийг зөвхөн эгц урдаас нь авч бүртгэлд оруулдаг байсан ч 1939 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн гэмт хэрэгтэн Товуугийн Түмэнгийн зургийг анх удаа Бертильоны аргаар буюу эгц урдаас нь болон хажуу талаас нь авч 4х5,2 см хэмжээтэй цаасанд буулган хэрэгт нь хавсаргаж байсан тухай баримт бас байдаг¹³.

Энэ гэрэл зургийн болон эрүүгийн тоо бүртгэл нь тухайн үед гэмт хэргийг илрүүлэх ажилд чухал ач холбогдолтой байсан.

Тухайлбал, Цагдан сэргийлэхийн байцаах түшмэл байсан хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Сосорын Юндэнгийн нэгэн дурсамжид: “Цагдан сэргийлэхийн дарга цагдаа нар хэргийг амархан олдог байсан нэг арга нь хэрэг зөрчил гаргаж болох этгээдүүдийг ажиглаж, гадарлаж хяналт сайн тавьдаг байсных юм. Жишээ нь: Хогийн барам, Хар чоно унадаг шилбийн Хөнхөр, Биеийн шар, Цэдийн Ёнхор, Задь хувилгаан, Шожгор Дорж нарын этгээдүүдийг бүртгэн авч хяналт тавьдаг байсан бөгөөд эзэнгүй хэрэг гарвал эдний доторшүүрдэхэд гол эзэн ньбуюу эсхүл тэдэнтэй ямар нэгэн холбоотой сэжиг заавал гардаг байсан юм”¹⁴ гэж байжээ.

Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд эрүүгийн хэргийн тоо бүртгэл хөтөлж түүнийг боловсронгуй болгох зорилгоор гэмт хэрэгтэн, сэжигтэн, яллагдагч нарын хурууны хээг авч бүртгэж эхэлсэн нь криминалистикийн шинжлэх ухааны ололт амжилтыг дүүрэн ашиглах боломжийг нээж өгсөн билээ.

Энэ үед криминалистикийн техникийн чухал хоёр салбар – гэрэл зураг болон гарын хээг ашиглан эрүүгийн тоо бүртгэлийг хөтлөхөд гол анхаарлаа хандуулж байв.

1944-1959 онд цагдан сэргийлэх байгууллагын үйл ажиллагаанд криминалистикийн онол, шинжлэх ухааны арга зүйг хэрэглэн гэмт хэрэг илрүүлэх ажилд гэрэл зураг болон хурууны хээний шинжилгээг ашиглах, хэргийн тоо бүртгэлийг хөтөлж, түүнд дүн шинжилгээ хийх болсон.

1958 онд Цэргийн ба Нийгмийг Аюулаас Хамгаалах Хэрэг Эрхлэх Яамны сайдын “Цагдан сэргийлэх газрын ажиллагаанд шинжлэх ухаан техникийн арга хэрэгслүүрийг нэвтрүүлэх ажлыг сайжруулах тухай” 600 тоот тушаалаар эрүүгийн хэрэгт шийтгүүлэгчдийн үсгийн дараалал болон

¹⁰Бүрэн засагчийн анхдугаар он 1862 онд байсан тул тавдугаар он нь 1866 он болно.

¹¹УАГ. М-1. Т-1. ХН 5007. Нугалбар бичгүүд

¹²Ш.Нацагдорж. Улаан хацарт. УБ. 1956. 5 дахь тал

¹³Бадарчи.С., Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэхэд криминалистикийн арга хэрэгслийг хэрэглэж байгаа нь. УБ., 1993 х.47

¹⁴Хурцгэрэл.Ж., Криминалистик I. УБ., 2002 х.47

хурууны хээний бүртгэлийг Улсын цагдан сэргийлэх газрын дэргэдэх Шинжлэх ухаан техникийн тусгай тасагт шилжүүлж хулгайлагдсан эд юм, сум хонгиог бүртгэх болсон байна.

Гэмт хэрэгтэй тэмцэхэд эрүүгийн хэргийн төвлөрсөн тоо бүртгэлийг байгуулах тухай НАХЯ-ны сайдын 1960 оны 6 сарын 24-ний өдрийн 769 тоот тушаалаар тэр үед Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтэст байсан ял шийтгүүлж суллагдсан бүх хүмүүсийн карт бүртгэлийг шинжлэх ухаан техникийн тусгай тасагт шилжүүлэн эрүүгийн хэрэгт шийтгүүлэгчдийг шалгаж байх үүргийг гүйцэтгүүлэх болжээ.

Энэ үед цагдаа, прокурор, шүүхийн байгууллагууд тус тусдаа тоо бүртгэл хөтөлж байсан бөгөөд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нэгдсэн тоо бүртгэл, судалгаа хийдэггүй байжээ.

МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1965 оны 305 дугаар тогтоолд гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг улам сайжруулах, гэмт хэргийн гаралт, түүнд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гүн гүнзгий судалж, эрүүгийн гэмт хэргийн болон урьдчилан сэргийлэх тоо бүртгэл хөтлөн, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах аппаратыг Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын дэргэд байгуулахыг заасан нь энэ албыг бие даан хөгжих үндсийг тавьжээ.

Сайд нарын зөвлөлийн 1966 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 422 дугаар тогтоолоор Улсын цагдан сэргийлэх ерөнхий газарт гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах ажлыг 1967 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хийлгэх болсноор энэ ажил эрхэлсэн тусгай тасгийг байгуулж, гарч байгаа эрүүгийн гэмт хэргийн байдалд дүн шинжилгээ хийж ажиллах болсон байна.

Энэ жилүүдэд гэмт хэрэг, түүнд холбогдогчдын тоо харьцангуй цөөн, жилд дунджаар 3.5-4.5 мянга хүрдэг байлаа. Гэхдээ цэргийн прокуроруудад үйлдэгдсэн хэргүүд мэдээнд /нууц гэдэг утгаар/ ордоггүй. Мөн гэмт хэргийг үйлдэл бүрээр биш хавтаст хэргээр тооцож мэдээнд оруулдаг үйл ажиллагааг зогсоох талаар Нийгмийг аюулаас хамгаалах яамны Сайдын тушаал гарч, бүх аймаг, хотуудын гэмт хэргийн ялын төлөвлөгөөг тоо бүртгэлийн тусгай тасагт төвлөрүүлэн авч үйлдэл нэг бүрээр уншуулан гэмт хэргийн мэдээнд оруулдаг болжээ.

Эрүүгийн гэмт хэргийн тоо бүртгэл, түүний шалтгаан нөхцлийг судлах тусгай тасаг нь улсын хэмжээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж шүүхээр шийтгүүлсэн бүх хэргийг нэгтгэн бүртгэж, тэдгээрийн шалтгаан нөхцлийг судалдаг байснаа 1980-аад оноос үйл ажиллагаа нь улам боловсронгуй болж, Улсын статистикийн газарт мэдээллээ нэгтгэж компьютерээр ангилан ялгаж, мэдээлэл бүрдүүлэх болсон байна.

Дүн шинжилгээ, мэдээллийн систем чухал ач холбогдолтойг харгалзан Нийгмийг аюулаас хамгаалах яамны Сайдын 1979 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 718 дугаар тушаалаар Дүн шинжилгээ мэдээллийн албыг штабын бүрэлдэхүүнд оруулж Гэмт хэргийн нэгдсэн тоо бүртгэлийн тасаг, Дүн шинжилгээ мэдээллийн тусгай тасаг болгон ажиллуулсан. 1986 оноос Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын штабыг татан буулгаж Дүн шинжилгээ, мэдээллийн хэлтэс болгон өөрчлөн зохион байгуулж, 1990 оны 6 дугаар сараас Захиргаа, боловсон хүчний хэлтэс болгон өөрчилж уг хэлтэс гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, шалтгаан нөхцөл судлах ажлыг давхар эрхлэх болсон байна.

Цагдаагийн ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай Засгийн газрын 1996 оны 249, Засгийн газрын 2000 оны 180 дугаар тогтоолоор Дүн шинжилгээ, мэдээллийн төвийг, Засгийн газрын 2002 оны 189 дүгээр тогтоолоор Мэдээлэл, судалгааны төвийг Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд оруулжээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 127 дугаар тушаалаар Мэдээлэл, судалгааны төвийг “Статистик мэдээллийн сан”, “Ял шийтгэлийн мэдээллийн сан”, “Мэдээллийн технологийн тасаг” гэсэн бүтэцтэй шинэчлэн батлуулав.

1970-аад оноос барууны орнуудад, 1990 оноос ОХУ-д удалгүй Монгол улсад зарчмын хувьд шинэ, автоматжуулсан бүртгэл, адилтгалын системүүд практикт нэвтэрч өнөө үед улам боловсронгуй болсоор байна.

Ийнхүү криминалистикийн бүртгэл нь гэмт хэрэгтнийг тамгалах, зэрэмдэглэх, шивээс хийх бүдүүлэг, хүнлэг бус аргуудаар эхэлсэн криминалистикийн бүртгэл өнөөдөр төрөл бүрийн бүртгэлүүдийг хооронд нь нягт уялдуулсан /интеграци/, нэгдсэн мэдээллийн сан бүхий автоматжуулагдсан хайлтын систем бүхий тогтолцоо болтлоо хөгжсөн байна.

Криминалистикийн бүртгэл үүсэж хөгжсөн түүхийг судалж үзэхэд түүнийг дараах байдлаар үечлэн үзэж болохоор байна.

I үе нь гэмт хэрэгтнийг зэрэмдэглэх, тамгалах ажиллагаагаар хязгаарлагдаж байсан;

II үед гэмт хэрэгтнийг зэрэмдэглэх, тамгалах, тэднийг тодорхойлон бичих аргыг хослуулан хэрэглэж байсан;

III үед криминалистикийн бүртгэлийн хөгжил нь антропометр, гарын хээ судлалын ололтуудтай холбоотой бөгөөд түүний шинжлэх ухааны үндэс бүрэлдэж эхэлсэн;

IV үед криминалистикийн бүртгэлийн онол бий болж хөгжих эхлэл тавигдсан;

V үед “Криминалистикийн бүртгэл”-ийн онол, түүний шинжлэх ухааны үндэслэлулам боловсронгуй болж хууль хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд криминалистикийн тоо бүртгэлүүд нэвтэрч эхэлсэн;

VI үеийн онцлог нь XIX зууны 60-аад оноос криминалистикийн бүртгэл, тоо бүртгэлүүд бүхэлдээ компьютержсэн;

VII үе нь өнөөгийн бидний амьдарч буй, даяаршиж буй эрин үеийн эхлэл буюу интернэт болон мэдээлэл дамжуулах, солилцох орчин үеийн техник, технологи бүхийолон улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг Интерпол болон бусад байгууллага бий болсон, тэдний үйл ажиллагаатай холбоотой.